【8С тасгийн С зэрэглэлийн өрөөний танилцуулга】

“Эмчлүүлэх цагт ч, амрах цагт ч өөрөөрөө байж чадах ганц өрөө”



◆С зэрэглэлийн үнэ (Орны нэмэлт үнэ)
Хямдарсан үнэ 33,000 иен (НӨАТ орсон)
※Ердийн үнэ 80,300 иен (НӨАТ орсон)

8С тасгийн С зэрэглэлийн өрөө нь 30 м^2-аас дээш талбайтай, уудам ганцаарчилсан өрөөнд угаалгын өрөө, ариун цэврийн өрөө, гар угаагуурыг тус тусад нь тохижуулсан, өндөр зэрэглэлийн эмчилгээ, сувилгааны орчин юм. Өрөөний дотоод засал чимэглэлийг намуухан өнгө аястай Европ маягаар хийж, буйдан, налуулдаг сандал, сейф, богино долгионы зуух, босоо ус буцалгагч зэрэг тав тухыг нэмэгдүүлэх тоноглолоор бүрэн хангасан. Мөн том дэлгэцтэй зурагт, Wi-Fi-аар тоноглогдсон бөгөөд уудам, тав тухтай эмчилгээний орчныг бүрдүүлсэн. Өрөөнд хувийн ажлын өрөө мэт уур амьсгалтай ширээ байх тул ном унших, захиа бичих зэргээр нам гүм цагийг өнгөрүүлэх боломжтой. Түүнчлэн буйдан дээр тухлан зурагт үзэх зэргээр гэртээ зочны өрөөндөө байгаа мэт ая тухтай амрах боломжтой.



Модыг голлон ашигласан засал чимэглэл, тав тухтай тоноглол нь таны эмчилгээний өдрүүдийг ая тухтай өнгөрүүлэхэд туслана. Уудам, тансаг уур амьсгалтай нам гүм орчинд сэтгэл амар эмчлүүлэх боломжтой тусгай зэрэглэлийн ганцаарчилсан өрөө юм.





Өрөө түс бүр тусдаа угаалгын өрөө, гар угаагууртай. Та хүссэн цагтаа усанд орох, биеэ заасах боломжтой тул эмчлүүлж байх хугацаандаа өөрийн хэвшсэн амьдралын хэмнэлээ хадгалан ая тухтай байх боломжтой.

【8C тасгийн С зэрэглэлийн өрөөний тоног төхөөрөмж】

- Буйдан ор
- Ширээ
- Орны хажуугийн ширээ
- Ажлын ширээ болон сандал
- Налуулдаг сандал, хөл тавих тавцан
- Том дэлгэцт телевиз
- Тусдаа угаалгын өрөө, ариун цэврийн өрөө, гар угаатуур
- Үс хатаагч
- Хөргөгч
- Богино долгионы зуух
- Босоо ус буцалгагч
- Сейф
- Шүүгээ
- Хувцасны шүүгээ
- Үнэгүй Wi-Fi
- Тусдаа агааржуулах систем

【Хэвтэн эмчлүүлэх үед авч ирэх зүйлс】

Манай эмнэлэгт эмнэлгийн хувцас, өдөр тутмын хэрэглэлийн түрээсийн иж бүрдэл бэлэн байдаг. Хэрэв та энэ түрээсийн үйлчилгээг ашиглахгүй бол доор дурдсан зүйлсийг бүгдийг нь өөрөө авч ирэх шаардлагатай.

Нүүр угаах, усанд орох хэрэгсэл

☐Шүдний сойз, оо ☐Шампунь, ангижруулагч ☐Биеийн саван ☐ Үсний сам
☐Шүдний хиймэл шүдний сав (шаардлагатай бол)
※Алчуурыг эмнэлгээс өдөр бүр бэлтгэх тул авч ирэх шаардлагагүй. (Өдөр бүр биеийн том алчуур 1, нүүрний алчуур 2, нэг удаагийн хөлийн дэвсгэр 1)

Өдөр тутмын хэрэгцээт зүйлс

☐Аяга (шаазан болон шилэн биш) ☐Салфетка

Хувийн эд зүйлс

☐Унтлагын хувцас (урд хэсгээрээ нээгддэг,сул, тухтай)
☐Дотуур хувцас ☐Амны маск
☐Дотор өмсөх гутал (Шаахай авчрахгүй байхыг хүсье. Ул нь халтирдаггүй, эвтэйхэн бөгөөд өсгий бүрхэгдсэн гутал, спорт гутал зэргээр ирнэ үү)

Одоо ашиглаж буй эм

☐Таны тогтмол хэрэглэдэг эм (хэвтэн эмчлүүлэх хугацаанд хэрэглэх хэмжээнийэмийг авчрана уу)

Бусад

☐Эмнэлгээс урьдчилан заасан зүйлс
☐Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тухай танилцуулга（Тусдаа гарын авлага)
※Дэлгэрэнгүй мэдээллийг «Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тухай танилцуулга»-аас харна уу.

Холбоос, Асуулт
Эрүүл Мэнд Нийгмийн Халамжийн Олон Улсын Их Сургууль Нарита Эмнэлэг
〒286-8520 Чиба муж, Нарита хот, Хатакеда 852
Даваа - Бямба гараг 8:30-17:15
※Ням гараг, амралтын өдрүүдэд амрана
Утас: 0476-35-5600

Эмнэлгийн вэбсайт

国際医療福祉大学 成田病院